



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2018 оны 09 сарын 17 өдөр

Дугаар 11/02

Дархан


Г Журам батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 2, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн “ж”, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтуудыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. “Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт сүм, хийд байгуулах, зөвшөөрөл олгох, хяналт тавих, сунгах, цуцлах журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү журмын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Насанбат/-д даалгасугай.
3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны “Журам батлах тухай” 49 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



Аймгийн ИТХ-ын 2018 оны ээлжит бус  
арваннэгдүгээр хуралдааны 11/02 дугаар  
тогтоолын хавсралт



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ СҮМ ХИЙД БАЙГУУЛАХ,  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ХЯНАЛТ ТАВИХ, СУНГАХ, ЦУЦЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийг Дархан-Уул аймагт хэрэгжүүлэх, шүтэн бишрэх эрхийнхээ дагуу иргэд сүм, хийд шинээр байгуулах, үйл ажиллагаа явуулах, зөвшөөрөл олгох, үйл ажиллагааны хугацааг сунгах, цуцлах асуудлыг энэхүү журмаар зохицуулна.

#### Хоёр. Сүм хийд шинээр байгуулахад бүрдүүлэх баримт бичиг

2.1. Сүм хийд байгуулах, үйл ажиллагааг явуулах зөвшөөрөл авахыг хүссэн иргэд аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:

2.1.1 тухайн шашны байгууллага байгуулахад үндэслэл, хэрэгцээ шаардлага, үйл ажиллагааны онцлогийг тусгасан өргөдөл;

2.1.2 Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан шаардлагыг бүрэн хангасан дүрэм;

2.1.3 шашны байгууллага байгуулахаар санал нэгдсэн хүмүүсийн хурлын шийдвэр, дэлгэрэнгүй тэмдэглэл;

2.1.4 шашны байгууллага байгуулахыг анх санаачлагчид, удирдах зөвлөл, үүсгэн байгуулагчид, ажиллагсдын товч бүртгэл /ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас, хүйс, регистрийн дугаар, боловсрол, мэргэжил, эрхэлж байгаа ажил, төгссөн сургууль, хэрэв суралцаж буй бол тухайн сургуулийн нэр, гэрийн хаяг, утас, цахим шуудангийн хаяг, зөвшөөрснийг гэрчлэх гарын үсэг/;

2.1.5 үйл ажиллагаа явуулах байршил, газар эзэмших гэрчилгээ, үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ, хэрэв түрээсийн байранд ажиллаж байгаа бол түрээслэгчтэй хийсэн гэрээ, нотариатаар баталгаажуулсан хуулбарын хамт;

2.1.6 шашны байгууллагаас тухайн шашны зан үйлийг явуулахад шаардагдах ном, судар, бусад шаардлагатай хэрэгслийн жагсаалт, түүхийн үнэт өв эдлэлийн жагсаалт, хөрөнгө санхүүгийн хэмжээ, эх үүсвэр, тусламж, хандив, зардлын тооцоо;

2.1.7 шашны байгууллагын зорилго, шүтэж итгэдэг номлолын үндсэн үзэл санаа, үйл ажиллагааны зарчим, хамрах хүрээ, төрөл хэлбэр, гадаад харилцааны талаарх танилцуулга;

2.1.8 шашны байгууллагаас шүтэн бишрэгчид, итгэгчдийн дунд зохиох ажлын гол агуулга, чиглэл;

2.1.9 тухайн шашны байгууллага байгуулахыг дэмжсэн баг, сумын Засаг даргын албан бичиг;

2.1.10 шашны байгууллагын номлол, сургаал айлдагч нь гадаадын иргэн бол **тохирсон ангиллын оршин суух “SH”, зөвшөөрөл бүхий гадаадын иргэн**, түүний бүртгэл, фото зураг, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх байгууллагын болон цагдаагийн байгууллагын тодорхойлолт, ажиллаж байгаа газрын тодорхойлолт;

2.1.11 нэр давхацсан эсэхийг тодруулсан Улсын бүртгэлийн байгууллагын лавлагаа;

2.1.12 шинээр зөвшөөрөл авахад холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг авна.

2.2 Хэрэв дээр дурьдсан баримт бичгийн бурдэл дутуу бол материалыг хүсэлт гаргагчид буцаана.

#### **Гурав. Үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг сунгуулахад бүрдүүлэх баримт бичиг**

3.1 Шашны байгууллагын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг сунгахад дараах баримт бичгийг бүрдүүлж, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст ирүүлнэ. Үүнд:

3.1.1 тухайн шашны байгууллагаас үйл ажиллагааныхаа хугацааг сунгуулах хүсэлтээ ирлэхийлсэн албан бичиг;

3.1.2 Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар

3.1.3 тухайн хугацаанд тус шашны байгууллагаас хийсэн ажлын товч тайлан;

3.1.4 зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргахаас өмнөх жилийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан;

3.1.5 хүсэлт ирүүлсэн шашны байгууллагын Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн болон байгууллагын дүрэмд өөрчлөлт оруулсан эсэх, хэрэв өөрчлөлт орсон бол уг өөрчлөлтийн талаарх мэдээлэл;

3.1.6 тухайн шашны байгууллагад ажиллагсдын тоо;

3.1.7 тухайн шашны байгууллагын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг сунгуулахыг дэмжсэн баг, сумын Засаг даргын албан бичиг;

3.2 Энэ журмын 3-д заасан баримт бичгийг тухайн сүм, хийдийн үйл ажиллагаа явуулах хугацаа дуусахаас нэг сарын өмнө аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст ирүүлнэ.

3.3 Хэрэв дээр дурьдсан баримт бичгийн бүрдэл дутуу бол хүсэлт гаргагчид материалыг буцаана.

#### **Дөрөв. Шашны байгууллага шинээр байгуулах болон үйл ажиллагааны хугацааг сунгах хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх**

4.1 Шашны байгууллага шинээр байгуулах болон үйл ажиллагаа явуулах хугацааг сунгах хүсэлтийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хүлээн авч, баримт бичгийн бүрдлийг журамд заасны дагуу нягтлан шалгана.

4.2 Энэ журмын 2.1, 3.1-д заасан хүсэлт баримт бичгийг ажлын 5 хоногийн дотор нягтлан шалгаж, журмын шаардлага хангасан тохиолдолд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанад хүргүүлнэ.

4.3 Аймгийн Засаг даргын Тамгын газраас жил бүрийн 2 дугаар улиралд шашны байгууллагуудын тайланг хүлээн авч, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралд оруулж хэлэлцүүлнэ.

4.4 Энэ журмын 6.2-т заасан хяналт шалгалтаар сүм хийдэд илэрсэн зөрчлийг арилгуулсны дараа зөвшөөрлийг сунгах эсэхийг шийдвэрлэнэ.

4.5 Шашны байгууллага шинээр байгуулах болон үйл ажиллагаа явуулах хугацааг сунгах хүсэлтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэхийн өмнө тухайн асуудлыг хариуцсан Хяналтын хорооны хурлаар хэлэлцүүлж, дүгнэлт гаргуулсан байна.

4.6 Шинээр шашны байгууллага байгуулах, үйл ажиллагаа явуулах хугацаа сунгуулах хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногт багтаан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж болох бөгөөд энэ тохиолдолд хүсэлт гаргагчид нэн даруй мэдэгдэнэ.

4.7 Шашны байгууллага шинээр байгуулах болон үйл ажиллагаа явуулах хугацааг сунгах хүсэлтийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид хурлаараа хэлэлцэн шийдвэрлэнэ.

4.8 Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид шинээр байгуулагдаж байгаа шашны байгууллагад үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг 1 жилийн хугацаатай олгоно.

4.9 Хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа, ямар нэгэн зөрчилгүйгээр ажилласан шашны байгууллагын үйл ажиллагаа явуулах эрхийг 3 жил хүртэлх хугацаагаар сунгаж болно.

#### **Тав. Шашны байгууллагын хүлээх үүрэг**

5.1 Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй шашны байгууллага нь НҮБ-ын Хүний эрхийн конвенци, Олон Улсын Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Монгол Улсын хууль тогтоомж, бүх шатны Хурал, Засаг даргын шийдвэрийг үйл ажиллагаандaa мөрдлөг болгоно.

5.2 Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан шашны байгууллага Улсын бүртгэлд бүртгүүлэн гэрчилгээ авах бөгөөд татварын болон нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлсэн байна.

5.3 Зөвшөөрөл бүхий сүм, хийд нь өөрийн салбарыг бусад газарт шинээр байгуулах тохиолдолд энэ тухай хүсэлтээ Журмын 2.1, 3.1-д заасан баримт бичгийн хамт аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст ирүүлнэ.

5.4 Тухайн сүм хийд үйл ажиллагаагаа зогсоохоор өөрөө шийдвэрлэсэн бол хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад албан ёсоор мэдэгдэж бүртгэлээс хасуулна. Энэ тухайгаа аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст 7 хоногийн дотор мэдэгдэнэ.

5.5 Шашны байгууллага сургалтын үйл ажиллагаа эрхлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

5.6 Шашны байгууллагын үйл ажиллагаа явуулж буй байр нь Монгол Улсын холбогдох стандарт, норм, нормативыг хангасан байна.

### **Зургаа. Хяналт тавих**

6.1 Зөвшөөрөл бүхий шашны байгууллагын үйл ажиллагаанд бүх шатны Засаг дарга нар хяналт тавьж ажиллана.

6.2 Хяналт, шалгалтыг дараах тохиолдолд хийнэ.

6.2.1 аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан;

6.2.2 тухайн шашны байгууллагын үйл ажиллагаатай холбоотой гомдол, санал ирсэн тохиолдолд;

6.3 Шалгалтын дүнгийн талаарх тайланг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралд тайлагнах ба хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар нийтэд тухай бүр мэдээлнэ.

6.4 Монгол Улсын тусгаар тогтолц, үндэсний аюулгүй байдал, уламжлалт зан заншил, үндэсний онцлогт харшилсан аливаа үйл ажиллагаа явуулсан нь тогтоогдвол тухайн шашны байгууллагын зөвшөөрлийг цуцлах хүртэлх арга хэмжээ авч, шаардлагатай бол хуулийн байгууллагад шилжүүлнэ.

### **Долоо. Хориглох зүйл**

7.1 Шашны байгууллага зөвшөөрөлд заагдсан байрлалаас өөр байршилд үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

7.2 Иргэдийн амралт, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор байгуулагдсан нийтийн эзэмшлийн зам талбай, байгууламж болон Газрын тухай

хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан нийтийн эдэлбэрийн газар шашин, сүм хийдийн зориулалттай барилга, байгууламж барихыг хориглоно.

7.3 Төрийн болон төсвийн байгууллага, төрийн өмчit ба орон нутгийн өмчit аж ахуйн нэгжийн барилга байгууламж, нийтийн зориулалттай орон сууцанд шашин, сүм хийдийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

7.4 Насанд хүрээгүй хүүхдийг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр сүм хийдийн үйл ажиллагаанд татан оруулахыг хориглоно.

7.5 Шашны байгууллага аливаа нам, эвсэлтэй хамтарч болон бие даан улс төрийн үйл ажиллагаа явуулах, санхүүжүүлэхийг хориглоно.

7.6 Шашин, сүм хийдийн үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор буяны үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

7.7 Олон Улсын Хүний эрхийн конвенци болон Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөн аливаа үйл ажиллагааг хориглоно.

#### **Найм. Зөвшөөрлийг цуцлах, үйл ажиллагааг зогсоох**

8.1 Шашны байгууллага нь үйл ажиллагаагаа зогсоохоор өөрөө шийдвэрлэсэн тохиолдолд;

8.2 Холбогдох хууль тогтоомж, энэхүү журмыг ноцтой зөрчсөн тохиолдолд;

8.3 Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс аливаа шашны байгууллагын зөвшөөрлийг цуцалж, үйл ажиллагааг зогсоосон тухай шийдвэр гармагц улсын бүртгэлийн байгууллага, тухайн шашны байгууллага байрлаж байсан нутаг дэвсгэрийн татварын болон цагдаагийн байгууллагад мэдэгдэж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана.

8.4 Шашны байгууллагын үйл ажиллагааг зогсоохоор гаргасан аливаа шийдвэрийг тухайн шашны байгууллага эс зөвшөөрвөл хууль тогтоомжийн дагуу шүүхэд гомдол гаргаж болно.

0<sup>00</sup>